**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ**
**ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 12 сарын 06 өдөр Дугаар А/24 Улаанбаатар хот

2017 оны жилийн эцсийн эд
хөрөнгийн тооллого хийх тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйл, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.2.1, 11.3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бэлчээрийн менежмент төслийн нэгж-ОНӨТҮГ-ын үндсэн хөрөнгө, эд материалын тооллого явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Г.Пүрэвсүрэн | Төслийн менежер |
| Гишүүд | Н.Ганболд | Тоног төхөөрөмжийн оператор |
| Нарийн бичиг: | Б.Баярцэцэг | Агрономч |

2. Байгууллагын өмч хөрөнгийн тооллогыг 2017 оны 12 дугаар сарын 06-ний өдрөөс 12 дугаар сарын 11- ны хооронд зохион байгуулж 2017 оны 12 дугаар сарын 12-ний өдөр байгууллагын удирдлагад танилцуулахыг тооллогын ажлын хэсгийн ахлагч менежер /Г.Пүрэвсүрэн/-т даалгасугай.

3. Тооллогын явцад өртгөө элэгдлээрээ нөхсөн буюу эвдэрч хуучран шаардлага хангахгүй болсон хөрөнгийг тоолж, худалдах, шилжүүлэх , акт тогтоон устгах талаар санал гарган зурагжуулж, нийслэлийн өмчийн харилцааны газраар дүгнэлт гаргуулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэн данс бүртгэлээс хасаж, тайлан тооцоонд тусгахыг нягтлан бодогч /Ц.Мөнхдөл/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ГАЛДӨЛ

УЛААНБААТАР ХОТ
БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ҮТҮГ
6046231 ± 1116117863

2150300061